



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 6 өдөр

Дугаар A/07

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх, ажиллах журмыг батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 269 дүгээр тогтоол, Эмнэлгийн ерөнхий захирлын 2018 оны A/270 тоот тушаалаар батлагдсан "ҮНТЭ-ийн хөдөлмөрийн дотоод журам"ын 7.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын хэмжээнд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, шалтгааныг тогтоох, акт дүгнэлт гаргах үндсэн чиг үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр, орон тооны бус байнгын комисс"-ын ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Комиссын гишүүдийн ажлын байрны тодорхойлолтод нэмэлт чиг үүргийг тусган ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга (П.Мөнхтуул)-д үүрэг болгосугай.
3. Комиссын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг холбогдох зардлын ангиллаас гаргахыг Санхүү, бүртгэлийн алба (Н.Урансүрэн)-нд зөвшөөрсүгэй.
4. Комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллахыг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Б.Түвшинтөр)-д даалгасугай.
5. Энэ тушаал батлагдсантай холбоотойгоор эмнэлгийн ерөнхий захирлын 2019 оны A/213 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭЧ



Б.ХИШИГЖАРГАЛ

000084

УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-УОХХСБОТБКАЖ

Улсын нэгдүгээр зорилтадын ерөнхий
захирлын 2024 оны 1 дүгээр сарын 1-ны
өдрийн дараалтушаалын нэгдүгээр
хавсралт

ATA9996 9077131
9023050128

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон
тооны бус байнгын комиссын бүрэлдэхүүн

1. Комиссын дарга:

Ц.Сэргжмядаг Инженерийн байгууламжийн албаны дарга

2. Нарийн бичгийн дарга:

Г.Дэлгэрмаа Халдварын сэргийлэлт, хяналтын албаны Тархвар
судлаач

Гишүүд:

3. С.Учрал Техникийн албаны дарга

4. Б.Энхтуул Захирлын ажлын албаны Дотоод хяналтын
мэргэжилтэн

5. О.Одончимэг Захиргаа, хүний нөөцийн албаны Хүний нөөцийн
менежер

6. П.Наранцэцэг Сувилахуйн албаны арга зүйч

7. Д.Лхамсүрэн Үйлдвэрчний эвлэл /ажилтны төлөөлөл/

УЛСЫН НЭГДҮҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА- YOXXСБОТБКАЖ

Улсын нэгдүүгээр төв эмнэлгийн ерөнхий
захирлын 2024 оны 27 дүгээр сарын 10-ны
өдрийн 10:00 дугаарт гушаалын хоёрдугаар
хавсралт

ATA9996 9077
9023050128

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ОРОН
ТООНЫ БУС БАЙНГЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

2024 он

 УЛСЫН НЭГДҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / / Хувилбар 2 Журмын дугаар..... УНТЭ-ЗАА- ҮОХХСБОТБКАЖ		

БАТАЛГААЖУУЛАЛТ

Энэхүү журмыг боловсруулсан, хянасан, баталсан болоод хүчин төгөлдөр байдлыг дараах хүснэгтээр баталгаажуулна.

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ	ОГНОО
БОЛОВСРУУЛСАН	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	Ж.Урантөгс		2023.12.08
ХЯНАСАН	Захирлын ажлын албаны дарга	Ц.Амаржаргал		
ХЯНАСАН	Сургалт, эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал	П.Анхтуяа		2023.12.25

	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА- ЮОХХСБОТБКАЖ

ХУУЛБАРЫГ ТАРААСАН БҮРТГЭЛ

Д/д	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ	ОГНОО	ТАЙЛБАР

 Улсын нийдүүзээр	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /..... .	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА- ЮХХСБОТБКАЖ

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмыг жилд 1-ээс доошгүй удаа хянана. Журамд тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж, удирдлагаар баталгаажуулж, өөрчлөлтийг доорх “Өөрчлөлтийн бүртгэл”-д тэмдэглэнэ.

Д/д	ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН БҮЛЭГ/ЗҮЙЛ/	ӨӨРЧЛӨЛТИЙН УТГА	ОГНОО	ГАРЫН ҮСЭГ

 УЛСЫН НЭГДҮҮЗЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА- YOXXCSBOTBKAJ

АГУУЛГА

Д/д	Гарчиг	Хуудас
1	Нийтлэг үндэслэл	5
2	Нэр томъёо ба тодорхойлолт	5
3	Урсгал диаграмм	6
4	Үндсэн үйл ажиллагаа	7-10
5	Гүйцэтгэлийн шалгуур (хэмжүүр)	10
6	Эрх үүрэг	10-11
7	Хариуцлага	11
8	Холбогдох баримт бичиг	11
9	Бусад	11
10	Хавсралт	12-14

Улсын нийтийн	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА- УОХХСБОТБКАЖ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Байгууллага (цаашид "ажил олгогч" гэх)-д гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судалж бүртгэх, тайлагнах, мэдээлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Байгууллагын хэмжээнд орон тооны бус байнгын комиссыг томилон, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх ажлыг хариуцуулна.
- 1.3 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм шинэчлэн батлах тухай" 269 дүгээр тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм" болон холбогдох бусад хууль тогтоомжийг тус тус баримтлан, үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4 Иргэн, хуулийн этгээд нь гэрээгээр ажил гүйцэтгэх, гүйцэтгүүлэх, машин механизм, тоног төхөөрөмж түрээслэх буюу бусад хэлбэрээр ашиглах үед гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг хэрхэн судлан бүртгэх талаар холбогдох гэрээнд тодорхой тусгасан байна. Энэ талаар гэрээнд тусгаагүй бол ажил гүйцэтгүүлэгч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд түүнийг судлан бүртгэнэ.

2. НЭР ТОМЬЁО БА ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1 **Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл:** Хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг;
- 2.2 **Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл:** Ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйлийг;
- 2.3 **Хурц хордлого:** Цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг;

 УЛСЫН НАГДУГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-YOXXСБОТБКАЖ

3. УРСГАЛ ДИАГРАММ

4.

КОМИСС БАЙГУУЛАХ		
ХАБАЭ-н орон тооны бус зөвлөлтэй хамтран ажиллана	Комисс хуралдах Комиссын ажиллах төвлөгөө гаргах	Комисс нь шаардлагатай тохиолдопд ЮО, ХХ-ын шалтгаан, хүчин зүйлийн талаар тухайн чиглэлээр терелжсэн ХНХЯ-ны хяналтын байцаагч болон ажил олгогчоос хараат бус мэргэжилтэн, шинжээч, маргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж болно.
Эмнэлгийн удирдах бүрэлдэхүүн болон холбогдох бусад ажилтныг оролцуулж шуурхай хуралдааныг зохион байгуулах	Сургалт явуулах Хяналт Төв, тасаг, албадын үйл ажиллагаа	
	Тайлан ▪ Зөвлөмж ▪ Санамж	

 УЛСЫН НАГДУУ ЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ҮОХХСБОТЬБКАЖ

5. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх.


- 5.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4.1-д заасан хөдөлмөр эрхлэгч иргэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод дараах тохиолдолд өртсөний улмаас гэмтсэн, өвчилсөн, эсвэл амь насаа алдсан бол акт тогтооно. Үүнд:
- 5.1.1.1 Ажлын байрандаа ажил үүргээ гүйцэтгэж байх үед;
 - 5.1.1.2 Ажил олгогч болон эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолтоор буюу дайчилгаагаар ажил, үүргээ гүйцэтгэж байх үед;
 - 5.1.1.3 Ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил, үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;
 - 5.1.1.4 Ажилтан ажил эхлэхийн өмнө болон дууссаны дараа ажлын байрандаа амрах, багаж хэрэгслээ эмхэлж цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;
 - 5.1.1.5 Ажилтан ажилдаа ирэх, буцах зам (ажлын байр болон ажилтай холбоотой сургалтад оролцож байгаа, түр болон байнга оршин суудаг газар, голлон хооллодог, цалингаа авдаг газрын хооронд) -даа бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед; (Энэ ослыг судлан бүртгэхдээ энэхүү журмын 4.2.6-д дурдсан нөхцөл байдлын чиглэл, маршрут, цаг хугацаа зэргийг үндэс болгоно).
 - 5.1.1.6 Ажил, үүргээ гүйцэтгэх үед байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхт болон химийн бодисын нөлөөлөл, биологийн гаралтай гоц халдварт евчин үүсгэгч, хөнөөх хэрэгсэл, сүйрэл, дэлбэрэлт зэрэг гамшгийн үед;
- 5.1.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимыг санаатай зөрчсөн болон согтууруулах ундаа мансууруулах бодис хэрэглэсний улмаас осолд өртсөн, гэмт хэрэг үйлдэх үед өөрийн биед гэмтэл учруулсан нь нотлогдсон тохиолдолд орон тооны бус байнгын комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн актад энэ тухай тусгайлан тэмдэглэнэ.

5.2 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиллах журам.

- 5.2.1 Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс (цаашид комисс гэх)-ыг ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий З-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулна.
- 5.2.2 Комиссын даргыг ажил олгогч томилно. Комисс нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд байгууллагын удирдах ажилтан болон ажилтны төлөөллийг оролцуулж, шуурхай хуралдааныг зохион байгуулж болно.
- 5.2.3 Комиссын хурлын шийдвэрийг нийт гишүүдийн олонхийн саналаар гаргана. Олонхийн ирцтэй хурлын шийдвэрийг хүчинтэйд тооцно.

 УЛСЫН НЭГДҮҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-YOXXCSBOTBBKAJ

- 5.2.4 Комиссын хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан тухайн байгууллагын бусад алба, нэгжийн ажилтнуудыг татан оролцуулж болно.
- 5.2.5 Ажил олгогч нь (Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол 3.5 заалт) үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдэд урамшуулалт олгоно.
- 5.2.6 Энэхүү журмын 4.2.1-т заасан комисс нь осолдогчийг нийгмийн даатгалд хамрагдсан эсэхийг үл харгалзан Хавсралт №1, "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн акт" (цаашид "акт" гэх)-ын дагуу судлан бүртгэнэ.
- 5.2.7 Комисс нь шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийн талаар Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны тухайн чиглэлээр мэргэшсэн хяналтын байцаагч болон ажил олгогчоос хараат бус мэргэжилтэн, шинжээч, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргүүлж болно.
- 5.2.8 Комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 48 цагийн дотор судлан бүртгэх бөгөөд акт үйлдэн комиссын дарга, гишүүд гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарсан байна.
- 5.2.9 Ажил олгогч үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан холбогдох актыг Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хүргүүлнэ.
- 5.2.10 Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн ослыг судлан бүртгэхтэй холбогдон гарах зардал (тээвэр, холбоо гэх мэт)-ыг ажил олгогч хариуцна.
- 5.2.11 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан (цаашид "осолдогч" гэх)-д анхан шатны тусlamж үзүүлэх, эмнэлэгт хүргэх, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусlamж үйлчилгээ үзүүлэх, яаралтай шинжилгээ хийлгэх, осол, хордлогын улмаас бий болсон аюултай нөхцөл байдлыг шуурхай арилгах, судлан бүртгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч бүрэн хариуцна.
- 5.2.12 Судалж бүртгэсэн акт, дүгнэлтийг 4 хувь үйлдэж, харьяа нийгмийн даатгалын хэлтэс, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчид хүргүүлэх бөгөөд осолдогч буюу түүний гэр бүлд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судалж бүртгэсэн актыг өгнө.
- 5.2.13 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажилтны эрүүл мэндэд хүнд гэмтэл, бэртэл учирсан, нас барсны улмаас мэргэжлийн байгууллагын шинжилгээ, магадлагаа шаардлагатай бол ажлын 21 хоногийн дотор судлан бүртгэнэ.
- 5.2.14 Комиссын үйл ажиллагаатай холбогдох албан хэрэг хөтлөлтийг комиссын нарийн бичгийн дарга хариуцаж баримтыг архивын нэгж болгон хадгална.
- 5.3 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэхэд бүрдүүлэх бичиг баримт.**
- 5.3.1 Осолдогч тус бүрээр гаргасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын акт;
- 5.3.2 Осолдогчоос авсан тайлбар, ярилцлагын тэмдэглэл, осолдогч нас барсан тохиолдолд гэрчийн тодорхойлолт, түүний ярилцлагын тэмдэглэл;

 УЛСЫН НЭГДҮҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ҮОХХСБОТБКАЖ

- 5.3.3 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байр, тоног төхөөрөмж, техник, багаж хэрэгслийн гэрэл зураг болон бүдүүвч зураг, схем, дүрс бичлэг;
- 5.3.4 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбоотой асуудлаар холбогдох хүмүүсээс авсан мэдээлэл, ярилцлагын тэмдэглэл;
- 5.3.5 Осолдогчийн ажилд орсон тухай шийдвэр, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авч байсан бүртгэл, сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон бусад шаардлагатай баримтын хуулбар;
- 5.3.6 Осолдогчид олгосон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн баримтын хуулбар;
- 5.3.7 Аюулгүй ажиллагааны дүрэм, журам, заавар, тушаал, хууль тогтоомжийн холбогдох хэсгийн хуулбар;
- 5.3.8 Тухайн ажлын байранд хийсэн эрсдлийн үнэлгээний хуулбар;
- 5.3.9 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар яаралтай мэдэгдэх хуудас;

5.4 Энэхүү журмын 4.2.12-д заасан тохиолдлыг судлан бүртгэхэд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын актад хавсаргах баримт бичиг.

- 5.4.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас учирсан гэмтлийн зэрэг, эмнэлгийн болон мэргэжлийн байгууллагын шинжээчийн дүгнэлт, лабораторийн шинжилгээ, туршилтын дүн;
- 5.4.2 Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);
- 5.4.3 Холбогдох хяналтын улсын байцаагч, мэргэжилтэн, шинжээч болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт (дүгнэлт гарсан тохиолдолд);
- 5.4.4 Осолдогч нас барсан тохиолдолд цогцост задлан шинжилгээ хийсэн тухай шүүх эмнэлгийн дүгнэлт;
- 5.4.5 Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоосон акт;

5.5 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тухай мэдээлэх, тайлан гаргах

- 5.5.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан талаар осолдогч өөрөө, эсхүл осол, хордлогыг анх харсан этгээд ажил олгогчид нэн даруй мэдээлнэ.
- 5.5.2 Ажил олгогч (комисс) нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаар дараах байгууллагад энэхүү журмын Хавсралт №2, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тухай яаралтай мэдэгдэх хуудас”-ын дагуу бичгээр болон утсаар мэдэгдэнэ.
 - 5.5.2.1 Осолдогчийн эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээнээс үл хамааран мэргэжлийн хяналтын байгууллагад;
 - 5.5.2.2 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас хүний амь нас хохирсон тохиолдолд цагдаагийн байгууллагад;
- 5.5.3 Ажил олгогч (комисс) нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх мэдээллийг хүлээн авмагц осолдогчид анхан шатны тусlamж үзүүлж, эмнэлэгт хүргүүлнэ.
- 5.5.4 Ажил олгогч нь цагдаа, хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын байцаагч, комисс судалгаа, шинжилгээ хийх хүртэлх хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авна.

УЛСЫН НАГДУУГАЗР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... ҮНТЭ-ЗАА-ҮОХХСБОТБКАЖ

- 5.5.5 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан ажлын байрыг хамгаалалтад авах нь ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, бусад ажилтны эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд сэргээр нэлөөлөхөөр бол ажил олгогч нөхцөл байдлыг дурс бичлэг, гэрэл зураг болон бүдүүвч зургаар баримтжуулсан байна.
- 5.5.6 Ажил олгогч, комисс нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх мэдээг Үндэсний статистикийн хорооноос баталсан маягтын дагуу мэргэжлийн хяналтын байгууллагад ажлын З хоногийн дотор хүргүүлнэ.
- 5.6 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлоготой холбогдсон маргааныг шийдвэрлэх**
- 5.6.1 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын талаарх акт, дүгнэлтийг ажил олгогч болон осолдогч (осолдогч нас барсан тохиолдолд түүний гэр бүл) зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны хяналтын ерөнхий газарт болон шүүхэд хандан гаргаж, холбогдох хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 5.6.2 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарснаас хойш 6 сарын хугацаа өнгөрсэн тохиолдолд акт, дүгнэлт нөхөн гаргахгүй.
- 5.6.3 Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч нь комиссоос гаргасан энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасан үйлдвэрлэлийн

осол, хурц хордлогын актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дүгнэлтээ тусад нь гаргана. Энэ тохиолдолд комиссоос гаргасан акт, дүгнэлтийн баталгаажуулах хэсэгт "Хүлээн зөвшөөрөөгүй" гэсэн тэмдэглэгээ хийж, ургийн овог, эцэг (эх)-ийн болон өөрийн нэрээ бичиж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарна.

6. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР (ХЭМЖҮҮР)

- 6.1 Журмын хэрэгжилтийг Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гүйцэтгэл, ажлын үр дүн, тайлан, дүгнэлтээр хэмжинэ.

7. ЭРХ, ҮҮРЭГ

7.1 Комисс дараах эрхтэй.

- 7.1.1 Үйлдвэрлэл, үйлчилгээний талбай болон ажлын байранд нэвтрэн орж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нөхцөл байдалтай биечлэн танилцах;
- 7.1.2 Мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө, тусламж авах зорилгоор шаардлагатай тохиолдолд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх ажиллагаанд мэргэжилтэн, шинжээч оролцуулах, ослын талаар техникийн тооцоо, лабораторийн шинжилгээ, туршилт хийлгүүлэх, осол гарсан ажлын байрны эрсдлийн үнэлгээг дахин хийлгэж, дүгнэлт гаргуулах;
- 7.1.3 Осолдогч болон осол, хурц хордлого гарах үед байсан гэрч, бусад этгээдээс тайлбар, мэдээлэл, ярилцлага авах, холбогдох бичиг баримттай танилцах;

 УЛСЫН НЭДҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-YOXXCSBOTBKAJ

7.1.4 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад шаардлагатай ажлын байр, техник хэрэгсэл, унаагаар хангуулах;

7.2 Комисс дараах үүрэгтэй.

- 7.2.1 Нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, судалж бүртгэх үйл ажиллагааг эхлүүлэх;
- 7.2.2 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаражад хүргэж болзошгүй бөгөөд бусдын амь нас, эрүүл мэндэд аюултай, ажлын байрны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан, орчны аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийг арилгах арга хэмжээг шуурхай зохион байгуулах талаар ажил олгогчид шаардлага тавих, зөвлөмж өгөх;
- 7.2.3 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх явцад гарсан иргэдийн гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, ажлын 3 хоногийн дотор магадлан шалгаж шийдвэрлэх;
- 7.2.4 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шалтгаан, хүчин зүйлийг судлан бүртгэсэн акт, дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл болон цаашид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаражас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, сээрэмжлүүлэх арга хэмжээг нэн даруй авах, ажил олгогчид шаардлага, зөвлөмж хүргүүлэх;
- 7.2.5 Комисс нь үйл ажиллагааныхаа талаар удирдлага, хамт олны өмнө жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнана.

8. ХАРИУЦЛАГА

- 8.1 Комиссын гишүүд нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2015 оны А/269 тогтоол "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм", УНТЭ-ийн Хөдөлмөрийн дотоод журам, энэхүү журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллаагүй тохиолдолд хариуцлага хүлээнэ.
- 8.2 Хууль тогтоомжид заасан холбогдох асуудлыг ажил олгогч нь эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шалгуулахаар хүргүүлнэ.

9. ХОЛБОГДОХ БАРИМТ, БИЧИГ

- 9.1 Монгол улсын "Хөдөлмөрийн тухай" хууль;
- 9.2 МУ-ын "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" тухай хууль;
- 9.3 Монгол Улсын Засгийн газрын 2015 оны А/269 тогтооолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, Хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм";
- 9.4 Холбогдох дээд шатны байгууллагын тогтоол, тушаал, шийдвэр;
- 9.5 Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"

10. БУСАД

- 10.1 Энэхүү журам нь байгууллагын Ерөнхий захирлын баталгаажуулснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 10.2 Холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, бодлогын баримт бичиг шинэчлэгдэх, өөрчлөгддэх бүрт хянаж, тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж тусгана.

 УЛСЫН НӨКҮҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ҮОХХСБОТБКАЖ

Хавсралт №1

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭСЭН АКТ

20... оны ... сарын өдөр

1. Аж ахуйн нэгж байгууллагын нэр:

.....

2. Байгууллагын хаяг: /Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамжны нэр/

.....

3. Өмчийн хэлбэр:

.....

4. Үйлдвэрлэлийн осол, хурц хорлогод өртсөн хүний овогнэр
 Төрсөн огноо: он.....сар..... өдөр, Нас
 хүйс..... Иргэний харьяалал:

Регистрийн дугаар

Нийгмийн даатгалын дэвтрийн дугаар.....

Албан тушаал

Боловсрол..... Мэргэжил

Ажилд орсон он сар..... өдөр,

Тушаал шийдвэрийн дугаар

Нийт ажилласан хугацаа....., Үүнээс тус байгууллагад..... шимтгэл
 төлсөн, ажилласан хугацаа

5. Аюулгүй ажиллагааны урьдчилсан болон анхан шатны зааварчилгаа авсан
 байдал

.....

.....

6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эсэх:
- Тийм бол хамрагдсанон сар өдөр

 УЛСЫН НЭДҮҮГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ҮОХХСБОТБКАЖ

7. Эрүүл мэндийн үзлэгт хамгийн сүүлд орсон: он сар..... өдөр
8. Оршин суугаа хаяг
.....
9. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан он сар..... өдөр цаг
..... минут
10. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан нэгж, тасаг, хэсэг, ажлын байрны
нэр:
.....
11. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын байдал /хөнгөн, хүнд, нас барсан/
.....
12. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн хүний тоо. /бүлэг осол эсэх/
.....
13. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын гэмтлийн төрөл, ангилаал:
.....
.....
14. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахад хүргэсэн шалтгаан, хүчин зүйл:
.....
.....
15. Комиссын дүгнэлт: Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг гаргахад шууд
нөлөөлсөн хүчин зүйл, шалтгаан, нөхцөл байдлын талаар тодорхой бичнэ.
Дүрмийн 2.2.-т заасан тохиолдолд тусгайлан тэмдэглэнэ.
-
.....
.....
16. Комиссын шийдвэр:
.....
.....
.....

АКТ ТОГТООСОН КОМИССЫН

ДАРГА: / /

ГИШҮҮД: / /

..... / /

..... / /

..... / /

 УЛСЫН НАГДУУГЭЭР	ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫГ СУДЛАН БҮРТГЭХ ЖУРАМ		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 2	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-YOXXCSBOTБКАЖ

Хавсралт №2

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГЫН ТУХАЙ ЯАРАЛТАЙ МЭДЭГДЭХ ХУУДАС

1. Аж ахуйн нэгж, байгууллагын нэр.....
 2. Нэгж, тасгийн нэр
 3. Осол, хурц хордлогын хэлбэр: хөнгөн, хүнд, хүн нас барсан, бүлэг осол /зурах/
 4. Осол, хурц хордлогод өртсөн хүний тоо
 5. Осол, хурц хордлого гарсанон сар өдөр цаг минут
 6. Мэдэгдэл өгсөн он сар өдөр цаг минут
 7. Осол, хурц хордлогын тухай мэдээлэл
-
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Энэхүү мэдэгдлийг

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

..... нарт өгсөн болно.

Тайлбар: Мэдэгдлийг бичгээр, утсаар өгч болно. Мэдэгдлийг утсаар өгсөн тохиолдолд хаана, хэнд мэдэгдсэн тухайгаа энэхүү хуудсанд бичиж, осол, хурц хордлогын материалд хавсаргана.

Мэдэгдэл өгсөн хүний албан тушаал

.....
.....
.....
.....
.....

/..... /..... /...../

/гарын үсэг/

/нэр/